



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 152

Номгон

Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж  
болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх  
ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 7.1.16 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх ажлын 2022 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 5.0 /таван сая/ төгрөгийг аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг тухай бүр зохион байгуулж үр дүнг тооцож ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220131